



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Эрүүл мэндийн
төвийн эргэлтийн бус хөрөнгийг дахин үнэлж,
балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/428 дугаар захирамж, “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан нийт 3,812,212.30 (гурван сая найман зуун арван хоёр мянга хоёр зуун арван хоёр төгрөг гучин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Налайх дүүргийн 4, 6 дугаар хорооны “Суварга налайх” өрхийн эрүүл мэндийн төвийн баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв (Л.Байгал)-д зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу дахин үнэлсэн дүнгээр бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн 4, 6 дугаар хорооны “Суварга налайх” өрхийн эрүүл мэндийн төв (Б.Динара)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Ц.Цэрэндулам)-т даалгасугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.САЙХАНБАЯР

D:\НӨХГТ\тушаал 2023\А тушаал.docx

1150500047

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2023 оны .04. дүгээр сарын .25.-ны өдрийн
А/..... дугаар тушаалын хавсралт



Дахин үнэлж, шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв

№	Нэр төрөл	Бүртгэсэн огноо	Ашигласан жил	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Тоо хэмжээ	Дахин үнэлсэн дүн	Цаашид ашиглах жил	Нийт дахин үнэлсэн дүн	Хөрөнгө шилжүүлж авах байгууллагын нэр	
1.Тоног төхөөрөмж													
1	Компьютер	2012	11	1,200,000.00	1,200,000.00	1,200,000.00	-	1	600,000.00	2	600,000.00	Налайх дүүргийн 4, 6 дугаар хорооны "Суварга налайх" өрхийн эрүүл мэндийн төв	
2	Принтер	2007	16	212,450.00	212,454.00	212,454.00	-	1	100,000.00	2	100,000.00		
3	Ерөндөг тавих багаж хэрэгсэл	2002	21	274,117.80	274,117.80	274,117.80	-	1	135,000.00	2	135,000.00		
4	Хөргөгч NBC	2015	8	1,449,350.00	1,449,350.00	1,449,350.00	-	1	750,000.00	2	750,000.00		
Тоног төхөөрөмжийн дүн				3,135,917.80	3,135,921.80	3,135,921.80	-				1,585,000.00		
2.Тавилга, эд хогшил													
5	Сандал	2016	7	34,000.00	68,000.00	68,000.00	-	2	15,000.00	2	30,000.00		
6	Эмийн тэргэнцэр	2017	6	390,000.00	390,000.00	390,000.00	-	1	180,000.00	2	180,000.00		
7	Ширээ	2007	16	98,290.50	98,290.50	98,290.50	-	1	45,000.00	2	45,000.00		
8	Ширээ	2008	15	120,000.00	120,000.00	120,000.00	-	1	60,000.00	2	60,000.00		
Тавилга, эд хогшлын дүн				642,290.50	676,290.50	676,290.50	-				315,000.00		
					3,812,212.30	3,812,212.30	0				1,900,000.00		